МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 05 өдөр Дугаар А/145 Мөрөн сум

Хөвсгөл аймгийн Хил хамгаалалтад
туслах хүчний зөвлөлийн 2022 оны
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Монгол улсын хилийн тухай хуулийн 50.1.1, 50.1.2, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлигаар батлагдсан "Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн 2022 оны нэгдсэн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажиллахыг Зөвлөлийн орлогч дарга, Хилийн 0257 дугаар ангийн захирагч (хурандаа У.Мөнхбат), Нарийн бичгийн дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (П.Ариунбат) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-т даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар
сарын ..05.... ний өдрийн ..A/145.. дүгээр
захирамжийн хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУСЛАХ ХҮЧНИЙ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын 2.6, 3.2 дугаар зүйл, Монгол Улсын хилийн тухай хуулийн 7 дугаар бүлгийн 51-55 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлигийг хэрэгжүүлэх, Улсын хил хамгаалалтад аймаг, сумын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх.

д/д	Хийгдэх ажлууд	Хугацаа	Төсөв, хөрөнгө	Хариуцагч	Хамтран хийж, гүйцэтгэх албан тушаалтан
Нэг. Зохион байгуулалтын чиглэлээр:					
1	Аймгийн Хил хамгаалах туслах хүчний Зөвлөлийн хурлыг зохион байгуулах	VI, XI сар	Батлагдсан төсөв	Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газрын дарга, П.Ариунбат	Хилийн 0257 дугаар ангийн захирагч, хурандаа У.Мөнхбат
2	Хил орчмын нутагт оршин суугчдад Хилийн тухай хууль, Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, Монгол улсын Ерөнхийлөгчийн 149 дүгээр зарлиг, бусад хууль хууль тогтоомжыг хэрэгжүүлж, хил орчмын дэглэмийн биелэлтэд хяналт тавих	Хагас жилд 1 удаа	Батлагдсан төсөв	Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газрын дарга, П.Ариунбат	Хилийн 0257 дугаар ангийн захирагч, хурандаа У.Мөнхбат, Сумдын Засаг дарга нар
3	Хилийн бүс зурваст аялал, жуулчлал, ашигт малтмалын хайгуул эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллага, хууль бусаар ашигт малтмал, байгалийн баялаг ашигладаг иргэдийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт тавьж, холбогдох арга	Улирал бүр	Батлагдсан төсөв	Хөвсгөл аймгийн Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, М.Алтаншагай	-Хилийн 0257 дугаар ангийн захирагч, хурандаа У.Мөнхбат, -Тагнуулын хэлтсийн дарга, хурандаа Ц.Баатардорж,

	хэмжээг авч хэрэгжүүлэх				-Цагдаагийн газрын дарга, дэд хурандаа Т.Ганхуяг
4	Хилийн бүс, зурваст ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд зохион байгуулж, үр дүнг тооцох	I-XII сар	Батлагдсан төсөв	Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газрын дарга, П.Ариунбат	-Хилийн 0257 дугаар ангийн захирагч, хурандаа У.Мөнхбат -Хөвсгөл аймаг дахь Онцгой байдлын газрын дарга, хурандаа Ё.Пүрэвсүрэн -Сумдын Засаг дарга нар
5	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд хилчдийн ар гэрийг хамруулж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх бодлого баримтлах	I-XII сар	Батлагдсан төсөв	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Я.Эрхэмбаяр	-Хилийн 0257 дугаар ангийн захирагч, хурандаа У.Мөнхбат, -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Г.Базар, -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Б.Оюунтуяа, -Сумдын Засаг дарга нар
6	Хөвсгөл аймгийн хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилээр хулгайлагдсан болон бэлчээрээр хил давж алдагдсан малын асуудлыг шийдвэрлэх комиссын үйл ажиллагааг идэвхжүүлж, Хөрш орны хамтарсан комиссын үйл ажиллагаатай туршлага судлуулах ажлыг авч	I-XII сар	Батлагдсан төсөв	Хөвсгөл аймгийн Засаг дарга, Хил хамгаалах туслах хүчний зөвлөлийн дарга, Ш.Идэрбаясгалан	Хилийн 0257 дугаар ангийн захирагч, хурандаа У.Мөнхбат, Сумдын Засаг дарга нар

	хэрэгжүүлэх				
7	Улирал цаг агаарын байдлыг харгалзан хариуцсан хэсгийн малчдын судалгааг авч, өвөлжилт хүндэрсэн тохиолдолд хилийн зурваст нутаглах айл, өрхөд зохих журмын дагуу зөвшөөрөл олгох	I,II улиралд	-	Хилийн 0257 дугаар ангийн захирагч, хурандаа У.Мөнхбат	Сумдын Засаг дарга нар
8	Дүйцүүлэх цэргийн алба хаагчдыг хилийн инженерийн байгууламж байгуулах, заставын тохижилт, үйлчилгээний ажилд дайчлан оролцуулах	III улиралд	-	Хөвсгөл аймгийн Цэргийн штабын дарга, Хурандаа С.Батхуяг	Хилийн 0257 дугаар ангийн захирагч, хурандаа У.Мөнхбат Сумдын Засаг дарга нар
9	Хилчид, хил хамгаалалтад туслах хүчний гишүүдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгуулах	III улиралд	Батлагдсан төсөв	Эрүүл мэндийн газрын дарга М.Үүрийнбаяр	Хилийн 0257 дугаар ангийн захирагч, хурандаа У.Мөнхбат, Сумдын Засаг дарга нар
10	"Нэг мянгат- Нэг агт" аяныг Хөвсгөл аймгийн хэмжээнд зохион байгуулах, үр дүнг тооцох /тусгай хөтөлбөр төлөвлөгөөгөөр/	II,III улиралд	-	Хөвсгөл аймгийн Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, М.Алтаншагай	Хилийн 0257 дугаар ангийн штабын дарга, Хөвсгөл аймгийн Сумдын Засаг дарга нар
11	Хилийн салбаруудын малын өвөлжөө, хаваржаа газрыг олгож, гэрчилгээжүүлэх	I улиралд	-	Хөвсгөл аймгийн засаг дарга, Хил хамгаалах туслах хүчний зөвлөлийн дарга, Ш.Идэрбаясгалан	Хилийн 0257 дугаар ангийн захирагч, хурандаа У.Мөнхбат, Сумдын засаг дарга нар
12	Улсын хил хамгаалалтад ар талын хангалтад хилчдийн хүнс болон агт уналгад ашиглагдаж байгаа албаны амьтадыг малын хөлийн албан татвараас чөлөөлөх ажлыг шийдвэрлэх	Хагас жил тутам	-	Хөвсгөл аймгийн засаг дарга, Хил хамгаалах туслах хүчний зөвлөлийн дарга, Ш.Идэрбаясгалан	Хилийн 0257 дугаар ангийн захирагч, хурандаа У.Мөнхбат, Сумдын засаг дарга нар

	үзүүлэх			дарга, Ш.Идэрбаясгалан	
Дөрөв.Хилчдийн нийгмийн хамгааллыг сайжруулж, ажиллаж амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр:					
20	Ханх шалган нэвтрүүлэх боомтын алба хаагчдын хотхоны өргөтгөлийн ажилд дэмжлэг үзүүлэх /Агуулах, гарааш, жагсаалын талбай, сургалтын танхим/	II-III улиралд	20,0 сая	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Б.Оюунтуяа	Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, М.Алтаншагай, Хилийн 0257 дугаар ангийн захирагч хурандаа У.Мөнхбат Ханх сумын засаг дарга
21	Хилийн 0117 дугаар салбар /Ханх/-ын орон сууцыг засварлах	I,II улиралд	20,0 сая	Хөвсгөл аймгийн Засаг дарга, Хил хамгаалах туслах хүчний зөвлөлийн дарга, Ш.Идэрбаясгалан	Хилийн 0257 дугаар ангийн захирагч, хурандаа У.Мөнхбат

ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУСЛАХ ХҮЧНИЙ ЗӨВЛӨЛ